

## Bayasgalan Batsuuri

Дээш авирч тоглоё гэхэд нь би зөвшөөрсөн  
Дээврийн шат эгц өөдөө.  
Их л гэнэн байж дээ, тэртээ өндрийн одод руу  
Инээлдсээр хүрчихнэ л гэж бодож байв даа.  
Доош үсэрч тоглоё, бас л би зөвшөөрсөн  
Догдлон гараа атгалцаад, нэг хоёрын гурваа гээд л  
Даанч итгэмтгий байж дээ, намайг газардахад  
Дагаж тэр буулгүй гараас минь алдуурч  
Дэвээд л, дэвээд л, бүүр өөдөө  
Нисээд явчихаж билээ, би хашхираад  
Эгц өөдөө, дээврийн шат руу  
Эхэр татан авираад л, авираад л.,  
Одоо эдгэж дээ, шарх минь аньж  
Одод руу гараа зангидаж уйлдгаа ч больж, гэвч  
Дэргэд минь тэр хааяахан ирж суугаад  
Дээс томж тоглох уу гэж итгэлгүйхэн гуйх юм.

\*\*\*

Жигүүртэй боловч үүлнээс цааш нисч чадаагүй  
Жижигхэн эрвээхий би нарны гэрэл, харанхуйн тухай  
Жил сар, орчлонгийн шаналан, өнгө гудайгч цэцэгсийн тухай  
Шинэ хуучин бясалгалыг далавчин дээрээ зурж, гэвч  
Шингэж явна, ширгэж явна үгүйсгэгч бүхний нөлөөнд.  
Хөрсөн цогцосыг минь номон завсраа нандигнах  
Хөдөөлүүлэгч охин чин хаа явна вэ?

(Rain of the 13<sup>th</sup> Month, 2009)

\*\*\*

Тэсч туулна л гэж эхэлсэн бидний замд  
Тэгсгээд чиний гэрэл бөхчихлөө.  
Үлээгээд чамайг хөөргөддөг  
Үгдэрсэн салхи ч цээжинд намжчихлаа.  
Харанхуйд чиний тухай бодох  
Хар нүд, инээмсэглэлийг чинь харах  
Хачин байлаа.  
Барьцгүй хийсгэлэн тэр сэтгэлээс  
Барьж зогссоноо мэдэхээс  
Хоосон агаарт тогтоод  
Хоёулаа алхсан гэж бодохоос  
Нүд сохлом их гэрлийн дунд  
Нүүр нүүрнээсээ бусдыг харахгүй байснаа санахаас  
Аймшигтай байтал,  
Итгэмээргүй байтал  
Ашгүй чиний гэрэл бөхчихлөө.

\*\*\*

Уйтгарлан суух ийм өдрүүдийн хэлхээс  
Удахгүй цуурайлах энхрий дуугаар чинь тасарна.  
Залуу насны амь шиг хачин будангуй өдрүүдээ  
Зам дээр үлдээчихээд би чамд инээмсэглэн очно.

Чамд зориулж би гэзгээ уртаас урт ургуулсан  
Цааш эргээд алхчихвал зуураад үлдээх олс болог!  
Чамд зориулж би сэтгэлээ угаар нь тайрсан  
Цаашид түүгээр хэн ч дээс эргүүлж бүү тоглог!

Одоо эцсийн хүсэл.., намрын жихүүн бороонд  
Охин хонгорын хоолой цуцан дуулахыг чагнах,  
Тэнгэрт нь даатгаад орхисон олон олон хүслээ  
Тэр бороотой цуг бууж хага хага үсрэхийг харах...

\*\*\*

Хурууны минь үзүүрээс уяатай алтан утасны  
Хурмаст руу цойлсон нөгөө үзүүрээс чи атган суугаа.  
Би итгэдэг, энэ орчлонд  
Биднийг холбосон ямар нэгэн шижим бий гэдэгт.

Хуруугаараа би тэнгэрээс дүүжигнээд  
Нуруугаа амьдрал руу харуулчихаад агаарт хөвөөд л байгаа  
Бодит амьдралдаа эргэн ирээч гэсэн  
Богинохон үгтэй захидлууд надад ирээд л байгаа  
Би итгэдэг энэ амьдралд  
Бидэнд зориулсан ямар нэгэн орон зай бий гэдэгт.

Галт тэрэгнүүд урдаа тийм урт шат тавьчихаад  
Газар дээгүүрээ л мөлхөөд байхаар заримдаа би цухалддаг ч  
Үүл болоод нар, тэдний дэргэд чи минь байхад  
Өчүүхэн төдий салхи дэгдэхэд л хөөрч чадах юм шиг санагддаг.

Тэгээд л би ямагт инээж, дээшээ ширтэж  
Тэндээс чи гараан сунгаж, намайг татаад л авах өдрийг  
Тэсгэлгүй ихээр хүлээж, хүлээн хүлээхдээ  
Тэнгэр болоод газрын хооронд  
Тэгийн төдий ч зай үгүй дээ гэж боддог...  
Би итгэдэг, энэ орчлонд  
Бидэнд зориулаагүй ямар ч зүйл үгүй гэдэгт...

\*\*\*

Мөрөөдлийнхөө байшинг барив.  
Мөнгөн гуу жаазанд чиний зургийг хийж  
Ханандаа өлгөчихөөд харж хэвтэхдээ  
Ёслол төгөлдөр энэ эзгүйрлийн  
Ёроолыг нь гартал хөнтөрчихөв.  
Хэнтэй ч хуваахгүйгээр хүртчихэж болох дарс-цаг хугацаа  
Хэсүүлчний нөмрөгтэй он жилүүдийг минь бас л энд зөөж  
Өөр эхлэл үгүй гэж ахин дахин хашхирахад  
Өлгөөтэй зураг нүдэн дээр минь хачин их хөгширчихлөө.  
Өвдөлт мэт цаг хугацааг шийтгэж  
Өө, миний мөрөөдлийн шорон нурчихлаа...

(Rain of the 13<sup>th</sup> Month, 2009)

\*\*\*

Хамгийн сүүлд хэзээ уйлснаа чамд хэлэхгүй.  
Хашааны завсраар яралзах нохойн соёо шиг эрэмгий цагаан өдрүүд  
Харван дүүлж айсуй, ирээдүйгээс  
Харин чи бүү ай, ирээгүйгээс

Гай зовлон бүгдээс чамайг л хамгаалах  
Гатлага онгоц шиг нүд минь  
Нулимсан дээрээ хөвсөөр л байна.

Ахиад зөндөө уйлах энэ л нүдээрээ  
Би чамайг ширтсээр л байна.  
Аз жаргал гэдэг энэ дээ гэж зүрх сэтгэл давтах тусам  
Нүд уйлахад бэлдсээр л байна.

(Rain of the 13<sup>th</sup> Month, 2009)

\*\*\*

Халгаж халгаж барьж авсан шүлгийн дэвтрээр дүүрэн  
Хайрлаж хайрлаж тавиад явуулсан шүтээн хүмүүс хөглөрнө  
Ургаж ургаж унаад л өгсөн навчсын найранд согтоод  
Амьдарч амьдарч гэнэтхэн уйдсан сэтгэл уймарч зогсоно.

Ээжээ, би гарч тоглож болох уу?  
Энэ амьдралаас гарч тоглож болох уу?  
Гарч тоглож болох уу? Энэ амьдралаас  
Гараа татаад авчихаж болох уу?

Мартагнал намайг хоосонтой сүлэхэд  
Цаг хугацаа илбэчний гараа даллан тохуурхана.  
Маргаашийн өөдөөс би ачаагаа тонуулчихсан жинчин шиг  
Хохирсон зүрхээ тэврээд очно.

Ээжээ, би гарч тоглож болох уу?  
Энэ амьдралаас гарч тоглож болох уу?  
Гарч тоглож болох уу? Энэ амьдралаас  
Гараа татаад авчихаж болох уу?



\*\*\*

Залуу давалгаан дээр суугаад юу ч юм бичиглэнэ  
Оройхон нь шууданч тагтаа далавчаараа цонх цохилно  
“Оддын тоогоор хүлээлт” гэж уншаад гар минь чичирхүйд  
Орхиод ниссэн шувуухайн өд хүйтэн хөлстэй.

(Rain of the 13<sup>th</sup> Month, 2009)

\*\*\*

Огторгуйн сиймхийгээр, ихээ өндрөөс  
Оддын тоосонд дарагдсан ганц навч айсуй...

Адтай салхинд хоргоогдоод адгаж бужигнаж яваа ч  
Амь судал халуухан, уймраа ганц навч аа...

Алгаа, зүрхээ, нүдээн тосоод би  
Амьдралд нэг их хайртайгаа мэдрэх шиг л болов.

Харь ертөнцийн гунигаас тасарч хийссэн навчийг  
Халуун алгаараа би энхрийлэн тосов.

Тэсгим булгийн уснаас нэгээхэн балгыг дусаах мэт  
Тэнгэрийн энэ навч юутай хүйтэнд хувилаа вэ...

Хумьсан алгаа би зөөлхөн нээгээд хартал  
Аньсан Буддагийн мэлмий алгуур гунигтай цэлмэлээ...

(Rain of the 13<sup>th</sup> Month, 2009)